



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№77 /521/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.05.15

Цаг үе, үйл явдал

БҮТЭЭЛЧ ХАМТ ОЛНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Өмнөговь аймагт ажиллаж байна. Өнөөдөр Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, Батлан хамгаалахын сайдын зөвлөх дэслэгч генерал Ц.Дашзэвэг, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, тус аймгийн Засаг даргын орлогч Н.Энхбат, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат нарын албаныхан Зэвсэгт хүчний АЦК-ын харьяа 065 дугаар ангийн тусгай салбаруудад ажиллалаа.

Батлан хамгаалахын сайдыг хүрэлцэн ирэхэд бие бүрэлдэхүүн жагсаж, ёслол төгөлдөр угтлаа. Салбаруудын захирагч хошууч Б.Улсбаяр, А.Сүрэнхүү нар тус тусын салбарын түүх, үйл ажиллагаа, дэвшүүлсэн зорилго зорилт, тулгамдсан асуудлуудаа танилцууллаа.

Үндсэн үүргээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ офицер, ахлагч нарын ажиллаж, амьдрах

орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан албан тушаалын орон сууцны барилга, салбарын байрлал дахь объектуудын засвар, тохижилт болон туслах аж ахуйг хөгжүүлж байгаагаа уламжилсан.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр салбаруудын бие бүрэлдэхүүнтэй уулзаж, Засгийн газрын үйл ажиллагаа, Батлан хамгаалах бодлого, зорилтын талаар танилцуулав. Тэрбээр "Алсын хараа 2050" болон "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэхэд Батлан хамгаалах Зэвсэгт хүчний үүрэг оролцоо өндөр байгааг онцоллоо. Түүнчлэн Батлан хамгаалахын эрхзүйн шинэчлэл, Зэвсэгт хүчний ирэх зууны өнгө төрх сайд, удирдлагуудаас гадна Зэвсэгт хүчинд алба хааж байгаа хүн нэг бүрээс хамааралтай гэдгийг онцлоод цаашид эрхэлсэн ажилдаа эзэн болж, хандлагаа өөрчилж, хариуцлагаа

нэмэгдүүлэхийг уриалсан юм. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин нь сүүлийн жилүүдэд хөнгөн хуягт техникүүдийг өөрсдөө үйлдвэрлэж, зэвсэглэлд туршсаны зэрэгцээ бага бууны сумны үйлдвэр байгуулах болсноор цаашид бүтээн байгуулагч салбар болох үндэс суурь нь тавигдсаныг салбарын сайд хэллээ.

Мөн цаашид Зэвсэгт хүчин болон Агаарын цэргийн зэвсэглэл техникийг шинэчлэх, хөгжүүлэхэд тал бүрээр дэмжихээ илэрхийлж, бие бүрэлдэхүүнд ажлын өндөр амжилт, гэр бүлд нь аз жаргал эрүүл энхийг хүссэн юм.

Төгсгөлд нь Батлан хамгаалахын сайд салбаруудад тулгамдсан зарим асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэхийг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгож, олон үйлдэлт ухаалаг дэлгэц болон портер машины түлхүүрийг гардуулан өгөв.

Ахлах дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

ЦЭРГИЙН ЭМЧ, СУВИЛАГЧ НАР ЛИВАН УЛСАД ЯВАГДАЖ БУЙ НҮБ-ЫН МАНДАТТАЙ UNIFIL ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГААНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭНЭ



сувилагч нартаа хүний нутагт атгасан гар шиг цул хамт олон байж үүргээ нэр төртэйгөөр биелүүлэн эх орондоо ирэхийн ерөөлийг өргөн дэвшүүлсэн юм.

Үргэлжлүүлэн Ливан Улсад үүрэг гүйцэтгэх цэргийн эмч, сувилагч нараа төлөөлж Цэргийн төв эмнэлгийн эмч хошууч Б.Болд үг хэлсэн юм. Тэрээр "бид бүхнийг үдэн гаргахаар хүрэлцэн ирсэн та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагааны түүхэнд нэгэн шинэ хуудсыг бичилцэх хариуцлагатай эрхэм үүргийн эзэн болсондоо баяртай байна. Аливаа зүйлийн анхдагч байна гэдэг амаргүй хэдий ч манай баг үүргээ нэр төртэйгөөр гүйцэтгэх болно гэдэгт итгэлтэй байна.



Манай бүлгийн бүрэлдэхүүнд урьд өмнө нь НҮБ болон ОУ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүргээ амжилттай гүйцэтгээд ирсэн туршлагатай алба хаагчид багтсан" гэлээ.

Дэслэгч Ө.НАСАНТОГТОХ

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Ливан Улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай UNIFIL энхийг сахиулах ажиллагаанд урьд өмнө нь цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэж байгаагүй билээ.

Тэгвэл тус ажиллагааны анхны шаг татаж Цэргийн төв эмнэлгээс 4 хүний бүрэлдэхүүнтэй баг үүрэг гүйцэтгэхээр бэлтгэл ажлаа хангажээ. Эл түүхэн үйл явдлын гэрч болж энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх эмч, сувилагч нартаа Цэргийн төв эмнэлгийн бие бүрэлдэхүүн болон ЗХЖШ-ын удирдлагын төлөөллүүд

хүндэтгэл үзүүллээ.

Энэ үеэр Цэргийн төв эмнэлгийн дарга хурандаа Т.Энх-Од Ливан Улсад үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнд хандаж хэлсэн үгэндээ 2002 оноос хойш өнөөг хүртэл хугацаанд давхардсан тоогоор 1000 орчим цэргийн эмч, сувилагч нар даян дэлхийн энх тайвны төлөө хүчин зүтгэж Монгол Улс тэр дундаа Зэвсэгт хүчний нэр хүндийг энхийн тавцанд өндөрт өргөж ирснийг онцлоод Ливан Улсад явагдаж буй тус энхийг сахиулах ажиллагааны анхны шаг татаж буй цэргийн эмч



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
10	6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	28

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,457	3,463
EUR	3,770	3,785
CNY	497	500.50
RUB	43.20	43.70
JPY	25.60	25.80
KRW	2.61	2.63

ЗУРХАЙ

2023.05.15 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 26

ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал: ЖАРГАЛ ҮРГЭЛЖИД ИРНЭ НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 05.15-20.22 Барилдлага: Рашаан ШҮТЭН БАРИЛДЛАГА: Сэрэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 688,378,496

Эдгэрсэн

Нийт: 660,812,004

Нас барсан

Нийт: 6,873,457

Цахим шууданд

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭР...



хамтран “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг амжилттай зохион байгууллаа.

Уг хэлэлцүүлэгт БХЯ, ЗХЖШ, ҮБХИС, БХЭШХ, ДХИС, ОБЕГ, ХХЕГ, ЦЕГ, ДЦ, ТЕГ, ШШГЕГ зэрэг байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачид оролцож, төрийн цэргийн байгууллага болон хууль сахиулах байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааны эрх зүйн орчин, цэргийн алба хаагч, залуу боловсон хүчинд тулгамдаж буй нийгмийн болон албаны асуудал, нөхөн хангалт, удирдлагын шийдвэр гаргалт болон бусад асуудлаар тус тусын байгууллагын судалгаа шинжилгээний үр дүн, мэдээллийг хэлэлцлээ.

2024 онд ҮБХИС-ийн Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн үүсэн байгуулагдсаны 45 жилийн ой тохиож байгаа бөгөөд энэхүү ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөний хүрээнд тус хүрээлэн нь БХЯ, ЗХЖШ, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын төлөөлөл, “Монгол цэрэг, эх оронч залуучуудын холбоо” ГҮТББ-тай

ӨӨРИЙН ҮНДСЭН БАЙРЛАЛДАА БОЛОН ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ХИЙНЭ



Орон нутагт Зэвсэгт хүчний анги байгуулах нь Засгийн газрын урт хугацааны бодлогын баримт бичигт туссан. Зэвсэгт хүчний 341 дүгээр анги өөрийн үндсэн байрлалд болон Говь-Алтай аймгийн 100 жилийн ойд зориулан авто замын бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэхээр Алтай нутгийг зорин хөдөллөө.

Говь-Алтай аймагт Зэвсэгт хүчний анги шинээр байгуулагдаж байгаа нь Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэд, хүүхэд залуучуудад сурталчлан таниулах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, орон нутгийн төдийгүй бүс нутгийн хөгжил цэцэглэлтэд Зэвсэгт хүчний оролцоо нөлөөллийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Ахлах дэслэгч Г.ТҮМЭНБАЯР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 124 ДҮГЭЭР АНГИ “ҮНДЭСНИЙ МОД ТАРИХ ӨДӨР”-Т НЭГДЛЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар жил бүрийн 5 болон 10 дугаар сарын 2 дугаар долоо хоногийн амралтын өдрийг “Мод тарих үндэсний өдөр” болгон зарлаж, тухайн өдөр албан байгууллага, хувь хүн бүр үүргээ ухамсарлан нэг өдрийг мод тарьж өнгөрүүлдэг билээ. Энэхүү өдрийг угтаж ангийн байрлалд 4 төрлийн (улиас, хальс, шар хуайс, бургас) 450 суулгацыг суулгалаа.



БАЙЛДААНЫ СӨНӨӨГЧ ОНГОЦНЫ ҮЗҮҮЛЭХ НИСЛЭГИЙГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ



Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн байлдааны сөнөөгч онгоцны эскадриль, байлдааны сөнөөгч онгоцны засварын төв, нислэгт үйлчлэх батальоны бие бүрэлдэхүүн нислэг, нислэгийн аюулгүй байдал, нислэгийн урьдчилсан бэлтгэлийг хангаж, “Буянт-Ухаа” районд сургууль дадлагын нислэгийг гүйцэтгэлээ.

Тус өдөр Батлан Хамгаалахын сайд Г.Сайханбаяр болон албаны бусад бүрэлдэхүүн нисгэгч, инженер техникч, нислэгт үйлчлэх бие бүрэлдэхүүнтэй уулзаж, нислэгийн үйл явцтай

танилцан сөнөөгч онгоцны үзүүлэх нислэгийг үзэж сонирхсон юм.

Байлдааны “МиГ-29” сөнөөгч онгоцны нисгэгчид агаарт нислэгийн дасгалуудаас чадварлаг гүйцэтгэж, мэргэжлийн ур чадвараа ахиулсан сургууль дадлагын нислэгүүдийг амжилттай гүйцэтгэлээ. Ташрамд дуулгахад Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн нисгэгчид Монгол Улсад “Нисэх хүчин” үүсэж хөгжсөний 98 жилийн ойн ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд оролцож үзүүлэх нислэгүүдийг гүйцэтгэх юм.

Хошууч А.БААСАНПҮРЭВ

“БИДНИЙ АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ”



Зэвсэгт хүчний 325 дугаар анги 5 дугаар сарыг гэр бүлийн сар болгон зарлаж “Бидний аз жаргалтай гэр бүл” сэдэвт нэг сарын хугацаат аяныг өрнүүлж байна. Аяны хүрээнд ангийн нийт офицер, ахлагч, ажилтан алба хаагчдын гэр бүлийг ангийн байрлалд хүлээн авч ангийн үйл ажиллагаатай танилцууллаа. Үргэлжлүүлэн ажилтан, цэргийн алба хаагч нар ар гэрийн хамтаар “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг тохиолдуулан ангийн байрлалд өөрсдийн гэр бүлийн модыг тарьсан юм.



“ЦОЛ БҮХЭН САЙХАН” СПОРТЫН ОЛОН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНЭЭР...



Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн Ахлагчийн зөвлөлөөс “Цол бүхэн сайхан” спортын олон төрөлт тэмцээнийг зохион байгууллаа.

Тэмцээнд ангийн нийт бие бүрэлдэхүүн оролцож волейбол, билиард, теннис, дартсын төрлөөр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөхөд волейболын төрөлд ахлагч Н.Балжинням ахлагчтай “Ахлагч цолтон” баг тэргүүн байр, ахлах ахлагч Ц.Баттогтох ахлагчтай “Ахлах ахлагч цолтон” баг дэд байр, хошууч Н.Хүрлээ ахлагчтай “Хошууч цолтон” баг гутгаар байр, Дартсын төрөлд дэслэгч Н.Төрмөнх ахлагчтай “дэслэгч цолтон баг” тэргүүн байр, сургагч ахлагч Р.Бэхбаяр ахлагчтай “Сургагч ахлагч” цолтон баг дэд

байр, ахлах ахлагч Т.Баттогтох ахлагчтай “Ахлах ахлагч цолтон” баг гутгаар байр, Теннисний төрөлд хошууч Б.Мухамет захирагчтай “Хошууч цолтон” баг тэргүүн байр, ахлах ахлагч Б.Одонтүяа ахлагчтай “Ахлах ахлагч цолтон” баг дэд байр, ахлагч Б.Энхбаатар ахлагчтай “Ахлагч цолтон” баг гутгаар байр, Биллиардын төрөлд сургагч ахлагч Ц.Цэрэнсодном ахлагчтай “Сургагч ахлагч” цолтон баг тэргүүн байр, ахлагч Б.Баяржаргал ахлагчтай “Ахлах ахлагч цолтон” баг дэд байр, ахмад Р.Лхамаа ахлагчтай “Ахмад цолтон” баг гутгаар байрыг тус тус эзэлж мөрдэс нэгт нөхдөө манлайлсан юм.

Ахлагч

Б.НОМИН-ЭРДЭНЭ

ЦУГЛАРАЛТААР...




ЗХЖШ-ын МТГ-ын Техникийн хэлтсээс Зэвсэгт хүчний Төрлийн цэргийн командлал, БИЦУГ, нэгтгэл, анги, салбарын техникийн албан тушаалтнуудын нэгдсэн цугларалтыг зохион байгууллаа.

Цугларалтаар Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанаас “Тээврийн хэрэгслийн тооллого, техникийн хяналтын улсын үзлэгт хэрхэн бэлтгэх, анхаарах

асуудал”, “Зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөл”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал” гэсэн сэдвээр сургалт явуулж, цугларалтад оролцсон бие бүрэлдэхүүнд Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны дарга хурандаа Д.Дашдорж үүрэг, чиглэл өглөө.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБА

“БИДНИЙ ЭГШИГЛЭН”



Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн үлээвэр найрал хөгжмийн “Бидний эгшиглэн” тоглолт амжилттай болж өндөрлөлөө. Тоглолтод урилгаар “Voice” шоуны шилдэг оролцогч дуучин Э.Дашням хүрэлцэн ирж ая дууны мэндчилгээ дэвшүүлээ. Тус тоглолтыг Налайх цэргийн хүрээний ангиудын бие бүрэлдэхүүн болон цэргийн алба хаагчдын ар гэрийн төлөөллүүд хүрэлцэн ирж үзэж сонирхсон юм.

Ахлагч

Б.НОМИН-ЭРДЭНЭ